



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 96

Номгон

Их Богд хайрханыг Төрийн тахилгатай
уул болгох санал уламжлах тухай

Говь-Алтайн нурууны ноён оргил, мөнх цаст Их Богд уул нь далайн түвшнээс дээш 3957 метр өргөгдсөн, Монголын их говьд орших атлаа хангайн байгалийг санагдуулам номин ногоон хөвд ургамал, өнгө алаглах цэцэгсийн хүрээлэн, хүрхрэн шуугих өндөр уулын түргэн урсгалт гол горхи, газар хөдлөлтөөс тогтсон байгалийн өвөрмөц сонин тогтоц, нуур, дэлхийд ховордож дархлагдсан аргаль, янгир, ирвэс зэрэг ховор ан амьтад, ван сэмбэрүү, алтан гагнуур, лидэр зэрэг эмийн ургамлуудыг үзэж болох юм.

Их Богд уулын оргилд зуны дунд сард цас будран орж байхад уулын дунд хэсэгт бороо орж, бэл хоолойд нь 20-30 хэмийн халуун байдаг олон бичил уур амьсгалтай нутаг юм.

Их Богд ууланд 1957 онд хүчтэй газар хөдлөлт болж уулын нэгэн оргил тасран унаж хоёр голын хөндийг хааснаар эдүгээ “Хөх нуур”, “Ногоон нуур” нэртэй үзэсгэлэнт хоёр нуурыг бий болгосон нь гадаадын жуулчдын сонирхлыг гойд татдаг билээ. Ууланд аялагчдын сонирхлыг татдаг бүс нутгийн нэг нь их Богд уул юм.

Их говийн дархан газар, байгалийн сонин тогтоц олонтой. Их Богд уул, Ичээтэй, Жарангийн нуруу, Өлзийт, Ноён, Тариат, Бургатай зэрэг хараа булаам үзэсгэлэнт сайхан уулсаар чимэглэгдсэн бөгөөд Монголын улаан номд бичигдсэн олон ан амьтад бий.

Их Богд уул нь Жинст, Богд, Баянговь сумдын нутгийг дамнан орших улсын тусгай хамгаалалттай газарт өндөр уул, уулын хээр, хуурай хээр, цөлжүүхээр, цөлөрхөг хээрийн бүсийг хамарч говийн уулсын эко системийг бүрдүүлсэн газар нутаг юм. Эдгээр газарт манай улсад төдийгүй дэлхийд ховордсон амьтан, ургамалтайгаас гадна байгалийн үзэсгэлэнгээрээ гайхагддаг өвөрмөц сонин тогтоц бүхий уул нурууд, түүх, соёлын дурсалт газрууд, археологийн ховор олдвор зэргээр нэн баялаг нутаг билээ.

0117025

Говь-Алтайн бэлэрхэг уулын муж нь хэт гандуу цөлийн бүс, цөлжүү хээрийн бүсийн зааг дээр оршдог, хатуу ширүүн уур амьсгалын нөхцөлд орших боловч өндрийн нөлөөнөөс газар зүйн хэд хэдэн бүслүүрийг үүсгэн өвөрмөц орчныг бүрдүүлдэг.

Их Богд уул нь байгалийн өвөрмөц тогтоцтой, саланги тусгаар орших томоохон уулын систем үүсгэдэг бөгөөд уулынхаа хормойгоос шууд цөлжүү хээрийн бүсэд шилждэг, цөлжилт хойшоо хангайн чиглэлд түрж байгаа өнөөгийн нөхцөлд говь цөлийн бүсийг тусгаарлан, цөлжилт, элсний нүүдлийн нөлөөг бууруулахад чухал үүрэгтэй.

Их Богд уулын хамгаалалттай бүс нь дээр дурдсанаар газар хөдлөлийн идэвхтэй хэсэгт хамаарагддаг бөгөөд 1957 оны 12 дугаар сард нэн хүчтэй /11-12 баллын/ газар хөдлөлт болж энэ хүчит шилгээлтээр 300 гаруй км урт газарт ангархай, ан цав үүсчээ. Энэ нь Монгол орны хэмжээн дэх 3 дахь томоохон газар хөдлөлт байсан юм. Сүүлийн жилүүдэд унтарсан галт уулууд сэргэж гамшиг учруулах болсноос улбаалан гадаад дотоодын судлаачид энэхүү хагарлыг судлахад ихээхэн анхаарч байна.

Хил залгаа орших сумдын багийн Иргэдийн нийтийн хурал, сум, багийн Засаг дарга, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, нийт иргэдээс Их богд хайрханаа Төрийн тахилгатай болгож, тусгай журмын дагуу хүндэтгэн тайх саналтай байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, сумд, холбогдох байгууллагуудын хүсэлтийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус аймгийн нутагт орших Их Богд хайрханыг Төрийн тахилгатай болгох талаар Жинст, Богд, Баянговь сум болон холбогдох байгууллагууд, иргэдээс ирүүлсэн саналыг сайшаан дэмжсүгэй.
2. Их Богд хайрханыг Төрийн тахилгатай болгох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсугай.
3. Их Богд хайрханыг Төрийн тахилгатай болгох асуудалтай холбогдох баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР